



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.14 № 01/16

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Луус сумын тусгай зориулалтын сангуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 172,345,044.00 /Нэг зуун далан хоёр сая гурван зуун дөчин таван мянга дөчин дөрвөн / төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Байгаль хамгаалах санд бүртгэлтэй 7,000,000.00 /Долоон сая / төгрөгийн дансны үнэ бүхий авто тээврийн хэрэгслийг Засаг даргын Тамгын газарт эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр шилжүүлсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3-т. /Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ./ гэж заасныг зөрчсөн

2. Жилийн эцсийн санхүүгийн тайланд нийт 165,345,044.00 төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 20 дугаар зүйл 20.2.6-т /Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/; заасныг зөрчсөн.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.2 /Өмч, хөрөнгийг зохих шийдвэргүйгээр бусдад зүй бусаар ашиглуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн/, 4.1.4-д /Байгууллага иргэдтэй үүссэн материал дүнтэй буюу насжилт өндөртэй, авлага өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй / заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:


000000034

1. Цаашид эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг хийж байх.
2. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах, хууль, хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;
3. Дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй ажиллах;
4. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2017 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлэхийг Луус сумын Засаг дарга /Л.Цогзолмаа/, нягтлан бодогч /Б.Доржханд/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:


Шинжээч


С.Жалбаа

ЗӨВШӨӨРСӨН:

Дарга

Нягтлан бодогч


Л.Цогзолмаа
Б.Доржханд

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.